

Монголын Нууц Товчооны нэгэн хэлцийн орчуулгын тухайд

Д.Отгонтуяа
МУИС. МХСС

Монголчуудын соёлын аугаа их дурсгал болох Монголын Нууц Товчоон /МНТ/ нь дэлхийн 21 хэлээр орчуулагдсан байна. Анх Хятад хэлээр XIV зууны үед орчуулагджээ. Англи хэлээр МНТ-ны товч орчуулгыг анх 1952 онд Вей Квей Сун /Wei Sung/ Medieval India Quarterly сэтгүүлд хэвлүүлсэн бөгөөд хожим нь 1957 онд ном болгон гаргажээ. 1982 онд Америкийн эрдэмтэн Ф.В.Клиvez /Francis Woodman Cleaves, 1911-1995/, 1984 онд Пол Кан /Paul Kahn/, 2001 онд Өргөнгөө Онон /Urgunguu Onon/, 1971-1986 оны хооронд Австралийн эрдэмтэн Игорь де Рахевильц /Igor de Rachewiltz / “Алс Дорнодын Түүх” сэтгүүлд цувралаар гаргаж байгаад /Papers on the Far Eastern History of the Australian National University/ 2004 онд хоёр боть болгон хэвлүүлсэн байна. Орчуулагч Н.Доржготов, З.Эрэндоо нар хамгийн сүүлд 2006 онд орчуулсан билээ. Энэхүү өгүүлэлд Монголын Нууц Товчооны 234-р зүйлийн

*qoq idejii
qoma'uł tülejii*

гэсэн хэлцийн талаар гадаад дотоодын эрдэмтдийн орчуулж хөрвүүлж тайлбарласныг харьцуулан авч үзье.

1. ... хог идэж /2/ хомоол түлж явтугай ...

/2/ хог идэж: үйрсэн өвс идэж.¹

2. ... хог идэж хомоол түлж /1/ явтугай ...

/1/ хог идэж хомоол түлж – нүүдлийн хойноос хүмүүсийн үлдвэрийг идэж эдлэж явахыг дүрслэн хэлжээ. Хомоол гэгч нь морины хэт баас.²

3. ... хог идэж хомоол түлж /5/ явтугай /6/...

/5/ хог идэж хомоол түлж- хэмхдэг новш мэтийг хог хэмээмүй (“Шагж” нүүр 379. В).

Хадмал орчуулгад (**碎草**) хэмхдэг өвс гэв. Хомоол хэмээх нь адууны бөөн бөөн баасыг хомоол хэмээмүй (“Шагж” нүүр 348. А). Тус зүйлд Додайг нүүдэллэх үед гэрийн хойно яв хэмээн зарлиг болсон нь өмнө нь явж өнгөрсөн малуудад идэгдэж гишгэгдсэн хог өвс л үлдэх тул, түүний маллаж байгаа малууд нь зайлшгүй шинэ билчээрийн шинэ өвсний сорыг олж идэхгүй нь лав болмуй. Монголчууд энэхүү идэгдэж үлдсэн өвсийг хог хэмээмүй. “Хог идэж” хэмээвээс маллаж байгаа малыг заамуй. “Хомоол түлж” хэмээвээс ордны хойно нүүх хүмүүсийг заавай. Архай, Додайд хог новш ба өвс хог идүүлэх гэсэн үг биш. Нэн ч хог новш гэсэн санаатай үг биш бүлгээ.

/6/ Ордын хойноос хог идэж хомоол түлж явтугай- хэмээхийг Нака Мичиёгийн дэвтэр, нүүр 389-д “Орд өргөөний хойноос хагд (**桔草**) идэж, аргал (**干糞**) түлж явна” гэв. Тус өгүүлбэрийг Козины дэвтэрт “Хог (хаягдал) идэж, хомоол түлж” гэв. Кобаяши Такаширогийн орчуулга нь Нака Мичиёгийн орчуулгыг баримтлав. “Хог” хэмээх нь

¹ Монголын Нууц Товчоон. Ихмянгадай Иринчиний сэргээлт, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо, Хөх хот 1987, 222 тал

² Монголын Нууц Товчоон, Кү.Дорба орчуулав. Шинжааны Ардын хэвлэлийн хороо, 1987, 218 тал

олон утгатай бүлгээ. Шууд орчуулбал хог, ловш, лай (**垃圾**) хэмээмүй. Жишээлбэл: “Хогшил” хэмээх нь эд хөрөнгө, хөрөнгө гэсэн утгатай. Жишээлбэл: “Хогших” хэмээх нь “Хөрөнгө, гэрийн эд хогшилтой болох” гэсэн утгатай. “Хоггүй” хэмээвээс “Цэв цэвэрхэн, ор тас, хов хоосон” гэсэн утгатай. Эдүгээгийн Өвөр Монголын дорнодын зарим оронд, гадагш зам хөөх зуур үдлэхдээ унаа морио багахан өвс бордоо идуулэхийг харин “Хоглох” хэмээмүй.¹

4....Хог идэж

Хомоол түлж явтугай...²

5. ...Хог идэж

Хомоол түлж явтугай...³

6. ...Хог (үлдэгдэл) идэж хомоол түлж явтугай...⁴

7. ...Хог идэж

Хомоол түлж явтугай...⁵

8. хог идж, хомхл түлж йовтха!

... питаясь крохами и растапливая очаг трухой!

... хог эдижэ

Аргал түлижэ...⁶

9. ...отбросом питается, конским пометом отопляется⁷

10. ... хог эдижэ, тонтогоол түүжэ ябаг⁸

11. ...хог хамж

хомоол түлж явтугай*

* хог хамж хомоол түлж явтугай – Их нүүдлийн ард хаягдаж гээгдсэнийг бүрэн хамарч яв гэсэн үг болой.

Эдгээр эрдэмтдийн орчуулга тайлбараас үзвэл дараах хэдэн санаа гарч байна. Үүнд:

1. Үйрсэн өвс идэх /Ихмянгадай Иринчин/

2. Нүүдлийн хойно хүмүүсийн үлдээсэн зүйлийг идэж эдлэж явах /Кү.Дорба/

3. Хог үлдэгдэл /Д.Пүрэвдорж/

4. Үлдэгдлээр хооллох /С.А.Козин, Г.Дарбаев/

5. Өвсний хог үлдэгдлийг мал нь идэж Додай Черби өөрөө хомоол түлж яв /Элдэнтэй Ардажав/

Хятад хадмал орчуулгад “хог” хэмээх үгийг (**碎草**) “өвсний үлдэгдэл” гэж орчуулсанаас болоод олонхи судлаач, эрдэмтэд өвсний үлдэгдэл, хаягдал хэмээн орчуулж хөрвүүлсэн бололтой.

¹ Элдэндэй Ардажав, Монголын Нууц товчоон-Сийрүүлэл тайлбар, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөх хот 1996, 765-766 тал

² Далантайн Цэрэнсодном, Монголын Нууц Товчооны орчуулга тайлбар, Үндэстний хэвлэлийн хороо, 1993, 218 тал

³ Ш.Гаадамба, Монголын Нууц Товчоон, УБ 1990, 116 тал

⁴ Д.Пүрэвдорж, Монгол Улсын Нууц Товчооны шинэ орчуулга тайлбар, УБ 2006, 330 тал

⁵ Монголын Нууц Товчоо, Сонгомол эх УБ 2005, 121 тал

⁶ Сокровенное сказание монголов, Элиста 1990, 270 тал

⁷ Сокровенное сказание монголов, Перевод С.А.Козина, Монголой Нюуса Товшо, Ч.-Р.Намжиловай оршуулга, Улан-Удэ, 1990, 118,134 тал

⁸ Монголын Нууц Товчоон. Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” 1, УБ 2006, 182 тал

МНТ-ны эл хэлцийн англи орчуулгуудыг авч үзье.

1. Eating remnants [of blades] of grass [for food],
Burning dried dung [for fuel]⁹

Өвсний [үетний навчны] үлдэгдэл идэх [хүнсэндээ]
Малын хатсан баас түлэх [түлшиндээ]

2. His food will be the remnants of grass we leave,
his fuel the dried dung that's left behind.¹⁰

Бидний үлдээсэн өвсний үлдэгдэл түүний хоол,
Малын хатсан баас түүний түлш нь байх болно.

3. grazing his herds on pastures
already grazed by the herds of others,
and burning cakes of dried horse-dung* ¹¹

Малаа бэлчээрт адгуулж
бусдын малаа адгуулсан газарт,
адууны хатсан хомоол түлж

* ‘*Qoq*’ (хог) ‘хоолны шавхруу’ гэж энд орчуулагдсан бөгөөд ‘чанар муутай өвс’, ‘хивэг’, ‘хог’ гэсэн санааг бас илэрхийлж болно. ‘Dried horse dung’ гэдэг нь түлш бөгөөд тааруухан хатсан үхрийн баас гэж үзмүй.

4. Eating scraps of leftovers*,
Burning dried dung* ¹²

Хоолны шавхруу идэж
Малын хатсан баас түлж

* ‘Scrap of leftovers’ гэдэг нь Монгол хэлнээ ‘*qoq*’ (=*qoy*) гэж хөрвөнө. Хятад хадмал орчуулгын үгчилсэн утга нь ‘өвс хадах’ (碎草) боловч жинхэнэ утга нь ‘хог новш, шавхруу, хоолны үлдэгдэл, хог’ бөгөөд ярианы хэл, аялгуунд түүнчлээд бичгийн хэлнээс ч бид мэдэж болно. Энэ *qoq* ‘хог, шороо, үнс’ гэсэн үгийг уйгур хэлнээс авчээ.

* ‘Dried dung’ (түлш гэсэн утгаар) гэдэг үг нь *qota'ul* бөгөөд *qoq* гэдэгтэй толгой холбож байна. *Qota'ul* нь монголоор *qotoyol*, *qotool*, *qotul* (=*qotul*) ба ихэвчлэн адуу, илжиг, луусны баас юм.

5. He shall clean the campsite
And burn horse dung¹³

Тэрээр цэргийн хүрээг цэвэрлэж
Адууны хомоол түлинэ.

⁹F.W.Cleaves ‘The Secret History of the Mongols’, Harvard University Press, 1982, 171 pp

¹⁰Paul Kahn ‘The Secret History of the Mongols’, North Point Press, 1984, 147 pp

¹¹Urgunge Onon ‘The Secret History of the Mongols’, London, 2001, 220 pp

¹²Igor de Rachewiltz ‘The Secret History of the Mongols’, BRILL, 2004, 162 pp

¹³N.Dorjgotov, Z.Erendo ‘The Secret History of the Mongols’, Ulaanbaatar, 2006, 180 pp

Гадаад дотоодын эрдэмтдийн орчуулга, тайлбараас ‘*qoq idejū*’ гэсэн хэлцийг:

- Өвсний үлдэгдэл идэх /Ф.В.Клиvez, Пол Кан /

- Малаа бэлчээрт адгуулж /Өргөнгөө Онон /

- Хоолны шавхруу идэж /Игорь де Рахевильц/

- Цэргийн хүрээг цэвэрлэж /Н.Доржготов, З.Эрэндоо/

гэх зэргээр орчуулжээ. Ф.В.Клиvez Хятад хадмал орчуулгыг сайтар баримталсан учраас эхийнхээ утга санаанд илүү ойр болсон байна. Орчуулгуудын зарим тайлбар нь монгол хүний ахуй, сэтгэлгээг илэрхийлэн гаргах талаар учир дутагдалтай болжээ.

Энэхүү хэлцэд утгын хоёр төвшин байна.

1. Үгчилсэн (махчилсан) утгын төвшин

2. Шилжмэл утгын төвшин

Иймд энэ хэлцийн утгыг бүрэн төгс тайлъя гэвэл утгын энэ хоёр төвшнийг тус бүрчлэн нарийн нягт мөшгин үзэх хэрэгтэй. Хэлцийн эхний хэсэг болох “*qoq idejū*” гэдэг нь юу гэсэн үг вэ гэдгийг тайлахын тул эхлээд “*qoq*” гэдэг үгийн язгуурын утгыг сонирхож үзье. “Монгол үгсийн язгуурын тольд”: *qoq* гэдэг үгийг *qaγ*-ийн үүсмэл [Sečenčoγtu 1988, 1089]¹⁴ гэж үзсэн байх бөгөөд харин *qaγ*- хэмээх язгуурын нэгдүгээр утга нь “ямар нэгэн юмны дээгүүр тогтон дагширсан зүйл: шүдний хаг; толгойн хаг; тогооны хаг; төмрийн хаг”, хоёрдугаар утга нь: малын төрөхөд гарах хальс, навч буюу харвис ч гэнэ: үнээний хаг, гуравдугаар утга нь: мөөг, замаг хоёроос бүрэлдсэн доод зэргийн ургамал: (энд хадны хаг гэдгийг нэмж болох юм), хаг-замаг (Гомбожав нар, “Төвдийн хэлийг хялбар сурахуй нэрт бичиг”); *qaq usun* (*tebege*) (“Мукаддимат Ал-Адаб толь’’); дөрөвдүгээр утга нь: “хуучирсан” хатах, эгших, агирах, хагуух ч гэдэг “*edüge basa qaqči büküi čisun-i ama-bar simejū*” (МНТ, 145-р зүйл) (эдүгээ бас хатаж буй цусыг амаар шимж); “*sojiyasuban [=sojiyasu-ban] sumun-a tusdaju čisun inu qaqdaruṇ boguquṇ amayariyan [=ama-bar-iyan] simejū*” (МНТ, 173-р зүйл) (маханд нь сум тусч цус нь хатахад Борохул амаараа шимж) гэхчлэн тайлснаас гадна, зөрчид, уйгар, түрэг хэлээр бас [*xag-kag*], зүүн ёгор хэлээр [*xag*] гэдэг [дээрх номд, 900] нь алтай язгуурын бараг бүх хэлэнд ижилхэн байдаг гэж болно. Энэхүү язгуураас *qaγ- qaqqu- qaγuqu- qoγuqu- aγ- aγuqu- aqdaqu- agiraqu- aγaruul- aγarča- qaqdaqu- qataqu- qorud- qoryul- qakir-* гэх мэт үг бүр гарал нэгтэй бололтой. *Qaγ- qagi- qaγaji- qaγajiduqu- qaγajiraqu- qaγariqu- qaγariyul- qaγariyulqu- qaγariyuldaqu- qaγarimal- qaγuqu- qaγuljar- qaγurai- qaγurayilaqu- qaγurayidaqu- qaγuruly-a- qaγurqu- qaγury-a* (хуурсан зууш)- *qaγuryalaku- qaqlaku* (хаг суулгах, чигжих)- *qaqsaqu- qaqsay-a* (хагсах явдал)- *qaqsaγaqu* (эгшээх)- *qaqsaγalta- qaqsaγamal- qaqsaγu* (хуршигүй), *qaqsaγurqu- qaqsamal- qaqsaraqu* (хатах, хагсах)- *qaqsaray-a- qaqsarayan- qaqsaraγaqu- qaqsaraγulqu- qaqsiqu* (хаг суух)- *qaqsiyal* (хагшаас)- *qaqsiyasu- qaqsiyadasu- qaqsiraqu* (хагтах, хатах)- *qaqtuqu- qaqdaqu- qaqjiqu* (хагтах) [мөн ном, 900-901] гэсэн нэгэн язгууртай бүлэг үгсийн гол утгын цөм нь “**хатах**” гэсэн санаа байна. Үүнээс “*a-*”, “*o-*” хоёрын сэлгэдэг ёсоор “*qoq*” гэсэн өөр нэгэн үүсмэл язгуур үүснэ. *Qoq- qoγuqu- qoγula- qoγulai- qoγulayibči- qoγulayidaqu- qoγulayičin* (яриачин)- *qoγulančir* (хоолонцор, ховдог)- *qoγulančirdaqu- qoγulabči* (заам)- *qoγulabčilaqu- qoγulalqu- qoγulaly-a- qoγulayulqu- qoγulasay- qoγulasiku- qoγulači- qoγusun- qoγusuγar* (хоосноор)- *qoγusulaqu- qoγusulaγulqu- qoγusudaqu- qoγusudaγulqu- qoγusudqu-*

¹⁴ Sečenčoγtu. Mongol ūges-ün ijayur-un toli. Œbür mongol-un arad-un keblel-ün qoriy-a, 1988, 2973 [Sečenčoγtu 1988]

qоyusuraqu- qоyusural- qоyusurayulqu- qоyusuralta- qоyurmay- qоyurmaysiqu-
 qоyurmaytuqu- qоqlaqu- qоqlayulqu- qoqsiqu- qoqsil (эд хогшил)- qoqsiljiqu- qoqsiljiyulqu-
 qoqtuqu- qоqсi (зэрлэг ногоо)- qоqсin- qоqjirau- qоqjirautuqu- qоqjiraqu- qоqjiraгуulqu [мөн
 ном, 901] гэсэн бүлэг үгс үссэн байна. Эдгээрийн дотор бидний өнөөгийн нэг гаралтай
 гэдгийг огт санаанд оромгүй үгс ч байх бөгөөд анхны *qay* хэмээх язгуурын “хатах”
 гэсэн утга нь ямар нэг хэмжээгээр явсаар байна. Нэн ялангуяа “хогжируу, хогжруутах,
 хогжрох, хогжруулах” гэхэд энэ утга нь бүр тодорхой байна. **Чингэхлээр *qоq ideju***
гэсэн хэллэг бол “аливаа юмнаас үлдэж хатаж хоцорсон юмыг идэх” гэсэн шиг
анхдагч утга байна. Одоо энэ хэллэгийн хам бичвэрийг аваад үзвэл “Бүх хэшигтэн,
 тургуудыг орд орчин, орд гэрийн хөвүүдийг адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг
 Додай чэрби мэдэж орд байнга сахин атугай” хэмээн тушаав [Цэрэнсадном 2000, 154]¹⁵
 гэж бий. Энэ бол багачууд хүүхэд, мал ахуйн хэргийг хамаарч байхыг тушаасан санаа
 байна. Тэгэхлээр орд гэрийн хамаг баг идээнд дарагдах хүн нь Додай чэрби болж
 таарлаа. Эндээс *qоq ideju* гэсэн хэллэгийн анхдагч шууд утга нь “үлдсэн хатсан юм
 идэх” гэсэн утга боловч шилжсэн утга нь орд өргөөний аж ахуйн хамаг л ажлыг
 хариуцаж гэсэн утга мөн. “Хог идэх” гэсэн энэ үгэнд гэр өргөө тойрсон (орд орчин)
 хамаг ажил, эд хогшил (энэ үг чухамдаа “хог” язгуураас гаралтай) тохишуулах, үр
 хүүхдийг асран тэжээх, дөрвөн зүйл мал сүргийг адгуулах, бэлчээрлүүлэх бүх л ажил
 багтаж байна. Одоо цагийн монгол хэлний “баг идээндээ баригдах” гэсэн хэллэгтэй их
 ойролцоо утгатай.

Энэ хэлцийн хоёрдугаар хэсэг болох *qома'ul tүleju* гэдэг хэллэгийн хувьд
 орчин цагийн дөрвөд, баяд, хотон зэрэг олон ойрад аялгуунд *xomāl*, захчин, торгууд,
 өөлд, урианхай аялгуунд *xomoal* [Нутгийн аялгууны толь II, 1988, 426]¹⁶ гэж хэлдэг
 байна. Энэ бол “Монголын нууц товчооны” *qома'ul* гэдэгтэй бараг адилхан байна.
 Монгол угсаатны шидэт үлгэр, туульсын баатрууд морины хувхай хөх, тал хомоолд
 улбарин хувилдаг өгүүлэмж маш элбэг бөгөөд энэ нь хэнд ч үл анзарагдах, нүдэнд үл
 тусах нэгэн болж хувирсан гэсэн үг байдаг. Хэлцийн хоёрдугаар хэсэг болох *qома'ul*
tүleju гэдэг бол нүүдэлчин монгол хүний ухаарлаар бол мал малын гаралтай түлээ
 түлш дотроос үхрийн аргал мэтийн том товир түлшийг биш, адууны хомоол мэт хөнгөн
 авсаар түлш түлэх гэсэн үгчилсэн утга буюу сүүл барьж явах, ард явах, сүүлдэж явах,
 даруухан явах гэсэн шилжсэн утга болно. Орчин цагийн монгол хэл аялгуунд “хомоол
 хамах” гэсэн үг хэллэг байдаг нь мөн л сүүл барьж явах гэсэн шилжсэн утгатай билээ.
 Иймд *qома'ul tүleju* гэдэг бол нүүдлийн сүүл барьж, дуулиан шуугиангүй, даруухан
 явах гэсэн утга байна.

Ийнхүү бид энэ хэллэгийг англи хэлээр доорхи байдлаар орчуулах саналтай
 байна.

He will be responsible for campsite's work
 And follow the move modestly and quietly.

¹⁵ Цэрэнсадном Д. Монголын нууц товчоо (Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар). Улаанбаатар, 2000,
 386 т.х. [Цэрэнсадном 2000]

¹⁶ БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. Зохиогч Б.Амаржаргал, Г.Гантогтох,
 Ж.Цолоо. I, Халх аялгуу, Э/ш удирдагч Ч.Лувсандэндэв, редактор Чой.Лувсанжав, Д.Ёндөн, УБ., 1988,
 718 т. II, Ойрад аялгуу, 1988, 943 т.х. [Нутгийн аялгууны толь I, II, 1988]

Ном зүй

1. Ш.Гаадамба (1990) Монголын Нууц Товчоон, Уб, 116 тал
2. Кү.Дорба (1987) Монголын Нууц Товчоон. Шинжааны Ардын хэвлэлийн хороо, 218 тал
3. Монголын Нууц Товчоон (1987) Ихмянгадай Иринчиний сэргээлт, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо, Хөх хот, 222 тал
4. Монголын Нууц Товчоо (2005), Сонгомол эх, Уб, 121 тал
5. Ч.-Р.Намжиловай (1990) Сокровенное сказание монголов, Перевод С.А.Козина, Монголой Нюуса Товшо, Улан-Удэ, 118,134 тал
6. Д.Пүрэвдорж (2006) Монгол Улсын Нууц Товчооны шинэ орчуулга тайлбар, Уб, 330 тал
7. Сокровенное сказание монголов (1990) Элиста, 270 тал
8. Д.Цэрэнсодном (1993) Монголын Нууц Товчооны орчуулга тайлбар, Үндэстний хэвлэлийн хороо, 218 тал
9. Ш.Чоймаа (2006) “Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал” 1, Уб, 182 тал
10. Элдэндэй Ардажав (1996) Монголын Нууц товчоон-Сийрүүлэл тайлбар, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөх хот, 765-766 тал
11. F.W.Cleaves (1982) The Secret History of the Mongols, Harvard University Press, 171 pp
12. N.Dorjgotov, Z.Erendo (2006) ‘The Secret History of the Mongols’, UB, 180 pp
13. Igor de Rachewiltz (2004)‘The Secret History of the Mongols’, BRILL, 162 pp
14. Paul Kahn (1984)‘The Secret History of the Mongols’, North Point Press, 147 pp
15. Urgunge Onon (2001) ‘The Secret History of the Mongols’, London, 220 pp

Summary

In this article author deals with the phrase “*qoq idežü, qoma’ul tüležü*” of the Secret History of Mongols, its Mongolian and English translations’ explanations. According to the author, the component of the phrase “*qoq idežü*” means being responsible for campsite’s work and the component of the phrase “*qoma’ul tüležü*”means following the move modestly and quietly.